

# “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр

№ 24/38

Улаанбаатар хот

## Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 24/05 тоот тогтоол, ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааны эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа бөгөөд тус эрэлтийг хангах, өөрийн бүтээгдэхүүнийг зах зээлд үе шаттайгаар нэвтрүүлэхэд эх үүсвэрийн хэрэгцээ байгааг харгалзан “М банк”-аас энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасан нөхцөлийн хүрээнд нийт 7,500,000,000 (долоо аравны таван тэрбум) төгрөгийн зээл авахаар шийдвэрлэсүгэй.
2. “М банк”-тай энэхүү тогтоолын Хавсралт №1-д заасан нөхцөлийн дагуу Зээлийн гэрээ болон Барьцааны гэрээ байгуулах, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, холбогдох бусад арга хэмжээ авах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. “М банк”-тай байгуулсан Зээлийн болон Барьцааны гэрээний хэрэгжилт, зээл ашиглалт болон холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр

№ 24/39

Улаанбаатар хот

### Эх үүсвэр татан төвлөрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, 83 дугаар зүйлийн 83.8 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 24/05 тоот тогтоол, ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Капитрон банканд энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасан нөхцөлийн дагуу зээлийн хүсэлт гаргахаар шийдвэрлэсүгэй.
2. Капитрон банканд зээлийн хүсэлт гаргах, зээлийн судалгаанд шаардагдах аливаа баримт бичиг, мэдээлэл, материалыг бүрдүүлж хүргүүлэх зэрэг шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
3. Капитрон банкнаас зээлийн хүсэлтийг шийдвэрлэх үйл явц, шийдвэрийн талаар Компанийн ТУЗ-д эргэн тайлагнаж, Компанийн зээлийн хүсэлтийг Капитрон банкнаас хангаж шийдвэрлэсэн тохиолдолд зээлийн нөхцөл, зээлийн гэрээ болон шаардлагатай бусад асуудлыг Компанийн ТУЗ-д танилцуулан шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

